



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2022 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 05

Өлгий

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай

Сүүлийн үед улс орны хэмжээгээр хүүхдийн аюулгүй байдал нийгмийг нилээн цочроосон хурц асуудал болж, хүүхэд усанд живэх, сургуулийн биеийн тамирын талбайд амь нас алдах, тээврийн хэрэгслийн осолд өртөгдөх, мориноос унах зэрэг олон талт үзэгдэл газар авсантай холбогдуулан та бүхэнд дараах албан даалгаврыг хүргүүлж байна.

1. Өөрсдийн харьяа сургууль, цэцэрлэгүүдэд хүүхдийн аюулгүй байдал хэрхэн хангагдсан талаар үнэлэлт дүгнэлт гаргах ажлын хэсгийг даруй томилж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар ажил зохиох

2. Сургууль, цэцэрлэгийн орчим байрладаг биеийн тамирын талбай, тоглоомын талбайд байгаа хэрэгсэл бүрийн аюулгүй байдлыг хэрхэн хангасан талаар нэгбүрчлэн шалгаж, зөрчлийг арилгуулах, манаач, сахиул, харуул хамгаалалтад ажиллагсдын хариуцлагыг дээшлүүлэх, ажил хүлээлцэх журмыг сахин мөрдүүлэх, биеийн тамир, тоглоомын талбайн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавих

3. Сургууль, цэцэрлэгийн орчинд байрладаг цахилгаан дамжуулах шугам, түгээгүүр /трансформатр/-ын аюулгүй байдлыг шалгах, зохих арга хэмжээ авах

4. Объектийн орчинд байгаа ухсан нүх, жорлон, муу усны нүхний аюулгүй байдлыг хангах, журмын дагуу ариутгал хийх, хамгаалалтанд авах

5. Сургууль, цэцэрлэгийн урсгал засвар болон өвөлжилтийн бэлтгэл ажил хэрхэн хангагдсан талаар шалгаж, хугацаатай даалгавар өгөх

6. Тухайн сум, орон нутагт баригдаж буй барилгын объект, их засвар, урсгал засварт ажиллагсдын хөдөлмөрийн хамгаалалд хуулийн дагуу хяналт тавих

7. Багийн Засаг дарга нарт зуны амралтын үед хүүхдийн аюулгүй байдлыг хангуулах, насанд хүрээгүй хүүхдэд тээврийн хэрэгсэл жолоодох явдлыг цагдаагийн байгууллагатай хамтран таслан зогсоох, унаач хүүхдэд тавигдах шаардлагыг бүрэн биелүүлэх зэрэг ажлуудыг баг, сум орон нутагтаа зохион байгуулж, зохиосон ажлын тайлангаа Аймгийн Засаг даргын Тамгын газарт 8 дугаар сарын 20-25-ны хооронд ирүүлэхийг мэдэгдье.

00000011

8. Сумдад ажиллаж буй хүүхдийн эрхийг хамгаалах хамтарсан багийн ажлыг эрчимжүүлэх.

Хууль тогтоомжийг орон нутагтаа хэрэгжүүлэх ажил та бүхний үндсэн үүрэг бөгөөд түүнийг хэлбэрэлтгүй биелүүлэн шаардлагатай нөхцөлд зохих мэргэжлийн байгууллагын дэмжлэг туслалцаа авах, арга зүй удирдлагаар хангуулах нь зүйтэй.

Хувь хүний хариуцлагаас болсон аливаа золгүй явдалд төр засгийн удирдлагын хариуцлага хөндөгдөх болсон өнөө үед хүүхдийн амь нас эрүүл мэндийг хамгаалах талаар санаачлагатай ажиллахыг зөвлөж, хэрэв ямар нэгэн байдлаар хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд холбогдох хүмүүст хариуцлага тооцох болно гэдгийг анхааруулж байна.

